



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
АЛБАН БУС-НАСАН ТҮРШИЙН
БОЛОВСРОЛЫН ТӨВ



ЭКО ДҮҮРЭГ

“ЁС ЗҮЙН ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛ”

2022 ОНЫ ТАЙЛАН



2022 ОН

Ёс зүйн орон тооны бус зөвлөлийн 2022 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан

Албан бус-Насан туршийн боловсролын төвийн багш болон бусад ажилтан албан үүргээ гүйцэтгэхэд баримтлах зарчим, даган биелүүлэх ёс зүйн хэм хэмжээг тогтоож, ёс зүйн зарчим, хэм хэмжээ зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, багш мэргэжлийн нэр хүндийг хамгаалахад чиглэсэн ажлуудыг ёс зүйн зөвлөл удирдлага болгон ажиллаа.

2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс дагаж мөрдөх Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 12 дугаар зүйл, 13 дугаар зүйлийг үндэслэн Албан бус-Насан туршийн боловсролын төвийн захирлын 2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/27 тоот тушаалаар Ёс зүйн орон тооны бус зөвлөлийн даргаар Харилцаа ёс зүйн боловсролын багш, гишүүдээр Нийгмийн ажилтан-сэтгэл судлаач, Соёл гоо зүйн боловсролын багшийг томилсон.

БАЙГУУЛЛАГЫН ОРОН ТООНЫ БУС ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД

1. Санал асуулга авах

2022 оныг БШУЯ – наас “Ёс зүйн жил” болгосонтой холбоотойгоор байгууллагын ёс зүйн асуудлын талаар санал асуулга авч судалгаанд үндэслэн байгууллагын зарим албан хаагчтай уулзаж тэдгээрийн харилцааны асуудлын талаар танилцуулан үйл ажиллагаа зохион байгуулсан.

2. Ёс зүйн зөвлөл ажиллах үйл ажиллагааны үлгэрчилсэн журамыг танилцуулах

Ёс зүйн зөвлөлийн жилийн төлөвлөгөө болон ажиллах үлгэрчилсэн журамыг танилцуулж сайжруулан үлгэрчилсэн журам боловсруулан тушаал гаргасан.

3. Байгууллагын соёлыг мөрдүүлэх аян зохион байгуулах

Байгууллагын соёлыг мөрдүүлэх шинэчлэх батлах зорилгоор “Эерэгийг түгээе” сэдвээр өглөөний цай үйл ажиллагаа зохион байгуулсан. Манай байгууллага дээр хамт олны эерэг уур амьсгал бүрдүүлэх, санал бодлоо илэрхийлэх зорилгоор “Өглөөний цай” арга хэмжээг 3 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулж байна. Энэ удаа бид “Байгууллагын соёл”-ын талаар сургалт зохион байгуулж, 2020 онд хамт олны хурлаар баталсан Байгууллагын соёлоо хэлэлцэж, өөрчлөн сайжруулсан.



Зураг №1,2 ХУД АНБНТБТ өглөөний цай үйл ажиллагаа

4. Суралцагчдад ялгаварлан гадуурхалт, сургуулийн орчны ёс зүйн асуудлын талаар сургалт зохион байгуулах


Дүйцсэн хөтөлбөрийн ахлах ангийн 11 суралцагчдад сургалт зохион байгуулсан. Сургалтаар үе тэнгийн дээрэлхэлт болон хүүхдүүдийн хоорондын харилцааны агуулгын хүрээнд сургалтаа явуулж харилцан ярилцаж, эерэг харилцаатай байхыг уриалсан.



Зураг №3 Дүйцсэн хөтөлбөрийн ахлах анги

5. **Байгууллагын харилцааны уур амьсгалын талаар судалгаа авах**

Байгууллага дээрх ёс зүйн алдаа дутагдлыг сайжруулах, ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын албан хаагчдаас судалгаа авсан бөгөөд судалгаанд 11 албан хаагч хамрагдаж байгууллага дээр хүндлэл, боловсон харилцаа ёс зүйтэй байх зүйлс бага зэрэг дутагдалтай байна гэсэн үр дүн гарсан бөгөөд цаашид эдгээрийг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөлөө.



Зураг №4 Албан хаагчдаас авсан судалгаа

6. Ёс зүйн зөвлөлөөс **“ЭЕРЭГ ХАНДЛАГА-ЗӨВ ҮЙЛДЭЛ”** аяныг 11/01-11/30 өдрүүдийн хооронд зарлаж бие биедээ хүндэтгэлтэй хандаж, эерэг найрсаг харилцаатай, зөв үйлдлүүдийг дадал, хэвшил болгож хамтран ажиллахыг уриалж зохион байгуулсан.



Зураг №5 “Эерэг хандлага-Зөв үйлдэл” постер

Энэхүү аяны хүрээнд өдөр бүр бие биенээ хүндэтгэж, эерэг харилцааг зарчимаа болгон зөв боловсон харилцаж нэг нэгэндээ урам хайрлах, хийж буй ажлын хүрээнд өдөр бүр зөв үйлдлүүдийг гаргах, хэвшүүлэх, хамтран ажиллаж буй хүндээ эерэг нөлөөллийг үзүүлэх зэрэг үйл ажиллагаанууд зохион байгуулагдсан.



Зураг №6,7,8 “Эерэг хандлага-Зөв үйлдэл” аян

7. “Эерэг харилцаа-Зөв хандлага” өглөөний үулзалт зохион байгуулах

Хамт олны дунд эерэг харилцаа, хандлага бий болгох бие биенээ зөвөөр ойлгоход нөлөөлж хоорондын асуудлаа шийдвэрлэхэд туслах зорилгоор “Хамт олны ярилцлага” зохион байгууллаа. Ярилцлагаар ойрын үед байгууллага дээр хийгдсэн ажил, амжилт бүтээлийн талаар ярилцаж, хүсч буй хамт олны дүр төрхийг тодорхойллоо. Хүсч буй хамт олныг бий болгоход хувь хүн бүр харилцаан дээрээ юу анхаарах, ямар алдаа дутагдлаа засах талаар нээлттэй ярилцах зарчмаар нээлттэй хэлэлцүүлэг өрнөлөө.



Зураг №6,7,8 “Эерэг хандлага-Зөв үйлдэл” аян хэлэлцүүлэг

Дүгнэлт:

Ёс зүйн орон тооны бус зөвлөл 2022 онд дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах, ёс зүйн зөрчил гаргасан талаарх асуудлыг шалгаж, хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй эсэх талаар дүгнэлт гаргах, хууль, дүрэм, журмын талаар мэдээлэл сургалт сурчилгааны ажлуудыг хийх, хамт олны харилцаа, хандлага бий болгох, алдаа дутагдлаа засаж залруулах зэрэг ажил үүргийг хийж гүйцэтгэсэн байна.

Хамт олны хувьд цаашид эерэг уур амьсгалтай ёс зүйтэй орчныг бүрдүүлэх, ямар нэгэн зөрчил дутагдал, алдаа гаргахгүй хамтран ажиллах чиглэлээр ёс зүйн зөвлөл ажлаа төлөвлөж, улам боловсронгуй болгон ажиллах болно.

ТАЙЛАН БИЧСЭН:

ХАРИЛЦАА, ЁС ЗҮЙН БОЛОВСРОЛЫН БАГШ

Б.ЭРДЭНЭДУЛАМ

ТАЙЛАН ХЯНАСАН:

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР

Ч. ГАНТУЯА